

## Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын техникийн тодорхойлолт

### 1. Зорилго

Газрын тухай хуулийн 35, 58 дугаар зүйлд заасны дагуу газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг хийлгэж газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах үйл ажиллагаанд төрийн хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэх зорилгоор газрын төлөв байдал, чанарын тогтвортой, гол үзүүлэлтүүдийг хууль тогтоомжид заасан хугацаанд давтан тодорхойлж улсын хяналтад авсан анхны үзүүлэлтүүдтэй харьцуулан дүгнэлт гаргуулна.

### 2. Гүйцэтгэгчид тавигдах ерөнхий шаардлага

Газрын тухай хуулинд заасны дагуу Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

- Газрын мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрөлтэй байх
- Хөрс, ургамал, газар зохион байгуулагч нараас бүрдсэн орон тооны мэргэжилтнүүдтэй байх

Газар эзэмшигчийн захиалгаар эрх бүхий мэргэжлийн байгууллага тухайн газар дээр судалгаа хийсний үндсэн дээр тайлан боловсруулж газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгч, Ерөнхий шинжээчээр хянан баталгааны дүгнэлтийг баталгаажуулна.

Хянан баталгааны ажил гүйцэтгэж дууссаны дараах баримт бичгийн бүрдлийг захиалагч талд хэвлэмэл болон эх файлыг хүлээлгэн өгнө.

1. Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан 1%;
2. Нэгж талбарын сүлжээний зураг, тоон мэдээлэл /shp, jpeg, mxd/;
3. Хээрийн судалгааны бичиглэл, лабораторийн шинжилгээний дүн;
4. Эрх бүхий байгууллагаар баталгаажсан хянан баталгааны дүгнэлт 2%;

### 3. Хамрагдах талбай

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт Шинэ суурьшлын бүсийн 66 га талбай